



МОНГОЛ УЛС  
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2024 оны 06 сарын 06 өдөр

Дугаар A/293

Мөрөн сум

Усан замын тээвэрлэлтийн талаар авах  
зарим арга хэмжээний тухай захирамжид  
өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Усан замын тээврийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.4, 7.1.8, Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2.9, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, Захиргааны ерөнхий хуулийн 63 дугаар зүйлийн 63.1, 94 дүгээр зүйлийн 94.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Ус, цаг уур, орчны шинжилгээний төвийн ус судлалын Хөвсгөл нуур Хатгал, Хөвсгөл нуур, Ханх харуултуудын ажиглалтын мэдээгээр Хөвсгөл нуурын мөс 2024 оны 05 дугаар сарын 30-ны өдөр бүрэн хайлж дууссантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2018 оны 06 дугаар сарын 04-ний өдрийн А/332 дугаар захирамжийн 1 дэх заалтыг "Усан замын тээвэрлэлтийг 2024 оны 06 дугаар сарын 05-ны өдрөөс эхлүүлж, цаашид байгаль орчны нөхцөл байдлыг харгалзан хөвөлтийн эхлэх, дуусах хугацааг улирал бүр тогтоож байхаар шийдвэрлэсүгэй" гэж өөрчилсүгэй.

2. Усан замын тээврийн үйлчилгээ эрхлэгчдийг явалт тутамд бүртгэж, хяналт тавьж, тээвэрлэлтийн аюулгүй байдлыг хангуулж ажиллахыг Монгол Улсын Далайн захиргаа (Д.Отгонсүрэн)-д даалгасугай.

3. Усан замын тээврийн тухай хууль тогтоомжийг холбогдох төрийн байгууллагатай хамтран сурталчлан таниулж, хэрэгжилтийг зохион байгуулж ажиллахыг аймгийн Онцгой байдлын газрын дарга (хошууч С.Ганболд)-д үүрэг болгосугай.

4. Усан замын тээвэрлэлт эхэлж байгаатай холбогдуулан осол, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, байгаль орчныг хамгаалах, нийгмийн хэв журмыг хангуулах ажлыг хамтран зохион байгуулж ажиллахыг, аймгийн Цагдаагийн газар (Дэд хурандаа Д.Мөнхжаргал), Байгаль орчин, аялал, жуулчлалын газар (П.Мөнхжаргал), Хөвсгелийн улсын тусгай хамгаалалттай газрын Хамгаалалтын захиргаа (Г.Энхбаяр), Хөвсгөл нуур-Эгийн голын сав газрын захиргаа (Д.Эрдэнэболд) нарт тус тус үүрэг болгосугай.

5. Захирамжийг эс зөвшөөрвөл оролцогчдод мэдэгдсэнээс хойш 30 хоногийн дотор гомдол гаргах эрхтэй болохыг дурдсугай.

6. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч (М.Хуягбаатар)-д үүрэг болгосугай.

ДАРГА  
П.ЛХАГВАЖАВ

Захирамж 2024  
6717010897